



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



АРБИТРЫН МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭД ШҮҮХИЙН ОРОЛЦОО

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах
шатны шүүхийн шүүгч, доктор, дэд проф С.Энхбаяр



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТР



- ▶ Арбитрын тухай хуульд зааснаар Монголын Олон улсын ба үндэсний Спортын арибтр үйл ажиллагаа эрчимжиж, арбитрч нарын мэдлэг, чадварт тулгуурласан хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий шийдвэр гаргах нь нийгэмд чухал үр нөлөөтэй төдийгүй, спортын нэгдэл болон тамирчдын дунд зөвхөн шударга өрсөлдөөн, зүй ёсыг тогтооход чухал ач холбогдолтой.
- ▶ Бид спортын холбоод, тамирчид, тэмцээн уралдаан зохион байгуулагчдын үйл ажиллагаа зэрэгт спортын ёс зүйгээс гадна, хууль ёсны үйлчлэл, шударга ёсыг төлөвшүүлэхэд та бүхний шийдвэр үйл ажиллагаа чухал үүрэгтэй.



Шүүх хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд
арбитрын ажиллагаанд оролцож үл болно

1. Арбитрын маргаанд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийн оролцоо
2. Арбитрын хүчин төгөлдөр шийдвэрийг хянах хүрээ хязгаар
3. Арбитрын хэлэлцээрийг шүүх шийдвэрлэж буй өнөөгийн практик, анхаарах асуудал

Иргэний
хэргийн давж
заалдах
шатны шүүх

Анхан шатны
шүүх



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР

Арбитрын маргаанд хянан шийдвэрлэх
ажиллагааны явцад шүүхийн оролцоо

Арбитрын маргаанд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийн оролцоо /6.2/

1. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах /11.1/
2. Арбитрын ажиллагаанд нэг арбитрч оролцох үед талууд арбитрчийг томилох талаар тохиролцоонд хүрээгүй бол аль нэг талын хүсэлтээр арбитрчийг шүүх... томилно./ 13.4, 13.5/
3. Арбитрчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх /15.3, 16.1/
4. Талууд арбитрын харьяаллын талаар маргасан асуудал. /18.7/
5. Арбитрын бүрэлдэхүүн, эсхүл түүний зөвшөөрснөөр талууд нотлох баримт гаргуулахад туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг шүүх шийдвэрлэх /39.1/

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 160 дугаар зүйлийн 160.3-д заасан шийдвэр нь захирамж хэлбэрээр гарна

Арбитрчийг татгалзан гаргах

- ▶ Арбитрч, арбитрын бүрэлдэхүүн нь зөвхөн хараат бус, бие даасан байхаас гадна арбитрчийн ёс зүй, үнэнч шударга байдалтай шууд холбоотой бөгөөд арбитрч нь маргааныг хэргийн үйл баримт, бодит байдлыг тогтоохын тулд ямар нэгэн сэтгэлийн хөдлөл, хөндлөнгийн оролцоо, дарамт шахалтгүйгээр, аливаа хувийн сонирхолгүйгээр голч, шударгаар шийдвэрлэх үүрэгтэй.
- ▶ арбитрч нь бусдад буруу ойлголт төрүүлэхээс зайлсхийж, хэргийн оролцогч нартай тэгш хүнлэтгэлтэй харилцаж, тэдэнд хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл, үнэмшлийг өөрийн үйл ажиллагаа, үг яриагаар төрүүлэж чадахуйц харилцааны соёлыг эзэмшсэн байх ёстой.
- ▶ Арбитрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-д “...татгалзан гаргах хүсэлтийг хангаагүй бол хүсэлт гаргасан тал шийдвэрийг хүлээн авснаас хойш олон улсын арбитрын ажиллагааны хувьд 30 хоногийн дотор, дотоодын арбитрын ажиллагааны хувьд 14 хоногийн дотор **шүүхэд гомдол гаргаж** болно. Уг гомдлыг шийдвэрлэсэн **шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр** байна...” гэж заасан.



Шүүх арбитрчийг татгалзан гаргах хүсэлт шийдвэрлэх нь хэлбэрийн төдий байх хууль зүйн боломж

Арбитрчийн
татгалзан
гаргах хүсэлт



Шүүх хүсэлтийг хангасан тохиолдолд арбитрын шийдвэр хуульд нийцэх үү

Шүүх хүсэлтийг шийдвэрлэх хүртэл хугацаанд уг арбитрч шийдвэр гаргах процесст оролцохгүй байх

Арбитрч бүрэлдэхүүнд орж, үндсэн шийдвэр гаргах боломжтой



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



Арбитрын хүчин төгөлдөр шийдвэрийг хянах хүрээ хязгаар



Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээ

- Арбитрын хэлэлцээртэй маргааныг Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэж байгаа нь нэг талаас хүний эрхийг хангах хэрэгсэл, нөгөө талаас нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах механизм юм.
- Арбитрын шийдвэрийг хянах хүрээ нь Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-д зааснаар хязгаарлагдах бөгөөд хууль хэрэглээ болон шийдлийг шүүх хянах эрх хэмжээ байхгүй. Өөрөөр хэлбэл, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх нь процессыг хянаж, агуулгад орох эрх хэмжээ байхгүй.
- Арбитрын хэрэг маргаан хянан шийдвэрлэх нэг шаттай явуулах харьцангуй шуурхай процессын онцлогтой холбоотой.



а

арбитрын хэлэлцээрийн аль нэг тал эрх зүйн чадамжгүй, эсхүл арбитрын хэлэлцээр нь талуудын тохиролцон сонгосон улсын хуульд зааснаар, эсхүл тийнхүү тохиролцон сонгоогүй бол Монгол Улсын хуульд зааснаар хүчин төгөлдөр бус

б

өргөдөл гаргагч талд арбитрч томилох, арбитрын ажиллагааны тухай зохих ёсоор мэдэгдээгүйн улмаас арбитрын ажиллагаанд зохих ёсоор оролцох боломжгүй байсан

в

арбитрын бүрэлдэхүүн нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй, хамааралгүй маргааны талаар үндсэн шийдвэр гаргасан. Хэрэв нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй, хамааралгүй асуудлаар гаргасан арбитрын үндсэн шийдвэрийг нэхэмжлэлийн шаардлагад тусгасан асуудлаар гаргасан шийдвэрээс салгах боломжтой бол холбогдох хэсгийг хүчингүй болгоно

г

талуудын тохиролцоо нь арбитрын тухай хуулийн заавал дагаж мөрдөх заалтыг зөрчсөнөөс бусад тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа талуудын тохиролцоонд нийцээгүй, эсхүл тийнхүү тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа нь энэ хуульд нийцээгүй.

а

Монгол Улсын хуулиар уг маргаан арбитрын харьяаллын маргаан биш;

б

Арбитрын үндсэн шийдвэр Монгол Улсын нийтлэг ашиг сонирхлыг зөрчсөн

- ХБНГУ-ын Иргэний процессын хуулийн § 1059. Хүчингүй болгуулах хүсэлт нь манай Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлтэй яг тохирч байгаа нь манай хөрсөнд буухгүй, эрх зүйн ухамсар сэтгэхүйн онцлогт тохироогүй хэм хэмжээг шууд хуулбарлан хэрэглэсэн нь учир дутагдалтай байна.
- Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд арбитрын шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан гомдлын дийлэнх нь хууль хэрэглээ, арбитрын шийдэлтэй холбоотой гомдол зонхилж байгаа бөгөөд гомдол гаргахдаа 47 дугаар зүйлийн 47.2.1а, б, в, г-ийн аль нэг үндэслэлийг иш татан, гуйвуулан тайлбарлах хэлбэрээр гаргаж байгаа ажиглагдав.
- 47 дугаар зүйлийн агуулга тодорхой бус байгаатай холбоотой маргалдагч талуудын процессын эрхийг хөндөх тохиолдол цөөнгүй байна. Жишээлбэл, 47.2.1 г-д ямар процессын тохиолдол хамаарах эсэх нь тодорхой бус байна. Жишээлбэл, гэрч асуулгах хүсэлтийг хангасан атлаа гэрчийн оролцуулаагүй тохиолдолд хуульд нийцээгүй процесст хамаарах эсэх нь зэрэг олон нөхцөл байдал тодорхой бус байна.





МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



Спортын арбитрын маргааны онцлог, анхаарах асуудал



СПОРТЫН АРБИТРЫН МАРГААНЫ ОНЦЛОГ

талууд спортой холбоотой маргааныг Спортын арбитрт хандаж шийдвэрлүүлэхээр тохиролцсон тохиолдолд энэхүү дүрмийг хэрэглэнэ. Спортын арбитрт хандах болсон нь гэрээ, журам дахь арбитрын заалтаас эсвэл сүүлд байгуулсан арбитрын хэлэлцээрээс үүссэн эсвэл хороо, холбоо, клуб, гишүүн спортын аливаа байгууллагын дүрэм, журам, тусгай гэрээнд Спортын арбитрт давж заалдах гомдол гаргахаар заасан бол эдгээр байгууллагын гаргасан шийдвэрийг давж заалдахтай холбоотой маргаанд мөн энэхүү дүрмийг баримтална.

Эдгээр маргаан нь спортой холбоотой зарчимууд, спортоор хичээллэх, хөгжүүлэхтэй холбоотой санхүүгийн болон бусад ашиг сонирхол, эсвэл илүү ерөнхийдөө спортой холбоотой аливаа үйл ажиллагаа, асуудалтай холбоотой байж болно.

Талууд гэрээндээ Спортын арбитрыг тусгайлан заагаагүй бөгөөд аль нэг тал нь эхэлж Монголын Олон улсын ба Үндэсний Спортын арбитрт нэхэмжлэл гаргасан бол тус арбитр ажиллагаа явуулна.

НОТЛОХ АСУУДАЛ

27.4.1. Нэхэмжлэл
болон татгалзлын
үндэслэл болох
нөхцөл байдлыг
НОТЛОХ

ТАЛУУД
НОТЛОХ

Талууд арбитрын
ажиллагааны явцад
тайлбар, хүсэлт
гаргах, үг хэлэх,
нотлох баримт
гаргах, мэтгэлцэх
эрхээ адил хэлбэр,
хугацаа, удаа
дарааллаар тэгш
эдлэх боломжоор
бүрэн дүүрэн
хангагдсан байна.

Талууд тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч
этгээд нь өөрийн шаардлага, татгалзлын
үндэслэл болж байгаа нөхцөл байдлыг өөрөө
нотлох үүрэгтэй.

Бүрэлдэхүүн
маргааны бодит
байдлыг тогтооно.

Талууд Бүрэлдэхүүний шаардсан бичиг баримт, бодит нотлох баримт болон бусад нотлох баримтыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр, тогтсон хугацаанд гаргаж өгөөгүй бол Бүрэлдэхүүн хэрэгт цугларсан нотлох баримтын хүрээнд шийдвэр гаргаж болно.

гэрч дуудах

ШИНЖЭЭЧ
ТОМИЛОХ

үзлэг хийх
болон баримт
бичиг нэмж
гаргуулах

хуулиар
зөвшөөрсөн
бусад
ажиллагаа-
/туршилт хийх,
даалгавар
бичих г.м

Арбитрын
хуралдааны үед
шинэ нотлох
баримт бүрдүүлэх
шаардлагатай гэж
үзвэл Бүрэлдэхүүн
арбитрын
хуралдааныг
хойшлуулж болно.

УРЬДЧИЛАН
ШИЙДВЭРЛЭ
ЭХ

Бүрэлдэхүүн шаардлагатай бол талуудаас нэмэлт нотлох баримт шаардах бөгөөд эдгээрийг арбитрт ирүүлэх хугацааг тогтооно.

ЭРСДЭЛ

Нотлох баримтыг арбитрын хуралдаан эхлэхээс өмнө долоогоос доошгүй хоногийн өмнө арбитрт ирүүлэх бөгөөд хэрэв энэхүү хугацаа хэтэрвэл нотлох баримтыг хүлээж авах эсэхийг Бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.

ТОГТООХ
ПРОЦЕСС
ХЯЗГААРТАЙ

Талууд, тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээд нь хуурамч нотлох баримт гаргах буюу хууль бус аргаар цуглуулахыг хориглоно. Ийм арга хэлбэрээр гаргасан нотлох баримт нь нотлох чанараа алдах бөгөөд арбитрын шийдвэрийн үндэслэл болохгүй.

НОТОЛГООНЫ
ХЭРЭГСЭЛ

Арбитрын хэргийн нотлох баримт нь талууд, тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээдийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл /гэрээ хэлэлцээр, протокол, тодорхойлолт, төлбөрийн даалгавар, тооцооны баримт, тооцоо нийлсэн акт, хилээр нэвтрүүлэх барааны гаалийн мэдүүлэг, чанарын сертификат гэх мэт/ болон электрон хэлбэр дэх баримтууд, шинжээчийн дүгнэлт, эд мөрийн баримт, үзлэгийн тэмдэглэл зэргээс бүрдэнэ.

ХАМААРАЛТАЙ

ҮНЭН ЗӨВ

ЗАРЧИМ

АЧ
ХОЛБОГДОЛТОЙ

ХАМААРАЛТАЙ

НОТЛОХ БАРИМТ ГАРГААГҮЙН ҮР ДАГАВАР


...**нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болох үйл баримтад холбогдох нотлох баримтаар дэмжээгүй эсхүл ирүүлээгүй**, энэ талаар **тогтоосон хугацаа дууссан** бол Бүрэлдэхүүн арбитрын ажиллагааг дуусгавар болгох тухай шийдвэр гаргаж болно.

Хариуцагч **тогтоосон хугацаанд ирүүлээгүй** бол Бүрэлдэхүүн арбитрын маргаан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулна.

Талууд арбитрын ажиллагааны талаар болон хуралдааны товыг албан ёсоор хүлээн авсан боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй, эсхүл тогтоосон хугацаанд **нотлох баримтаа гаргаж өгөөгүй** бол Бүрэлдэхүүн ажиллагааг үргэлжлүүлж, **цугларсан нотлох баримтад үндэслэн** шийдвэр гаргана.



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



Арбитрын хэлэлцээрийг шүүх
шийдвэрлэж буй өнөөгийн
практик, анхаарах асуудал

Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтын агуулга

Арибтрын хэлэлцээртэй боловч шүүхэд нэхэмжлэл гаргасан

Тайлбар гаргахаасаа өмнө маргаж, харьяаллын талаар хүсэлт гаргасан

Арбитрын хэлэлцээрийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгоно.

Тайлбар гаргасны дараа маргасан

Арбитрын хэлэлцээрээс татгалзсан гэж үзэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ.


Арбитрын хэлэлцээртэй маргааныг шүүх шийдвэрлэх нь талуудын зарчимд харш

- ▶ Анхан шатны шүүхэд тайлбар гаргасан эсэхээс үл хамааран хэргийг хэрэгсэхгүй болгодог тохиолдолд бий.
- ▶ Арбитрын харьяаллаас маргалдагч талууд санал нэгтэй татгалзсан бол шүүх шийдвэрлэх тохиолдол байж болох юм.
- ▶ Харин, аль нэг тал нь арбитрын харьяаллын талаар маргаж байгаа тохиолдолд хариу тайлбар өмнө эсхүл хойно гэдгээр арбитрын хэлэлцээрийг шүүх шийдвэрлэх нь захимжгүй юм.
- ▶ Олон Улсын чиг хандлага нь арбитрын хэлэлцээрийг зөвхөн арбитр шийдвэрлэх, нэг шаттай байх, талуудын гэрээний эрх чөлөө, тохиролцоог хүндэтгэх асуудлыг нэгдүгээрт тавьж байна.






МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



Спортын арбитрын
хэлэлцээрийг шүүх
шийдвэрлэж шүүхийн
ТОГТООЛД ХИЙСЭН ДҮН
ШИНЖИЛГЭЭ

Спортын арбитрын маргаан

Нийт 8 гомдол



Ц.Гачилмаа нарын нэхэмжлэлтэй арбитрын маргаан

Нэхэмжлэлийн шаардлага: Монголын тэшүүрийн холбооны дүрмийн 2.2.2, 13.15 хүчингүй болгуулах үндсэн нэхэмжлэлтэй, МТХ нэр төр сэргээлгэх, гэм хор арилгуулах, тэшүүрийн холбооны дүрмийг өөрчилсний дараа дураараа ажилсныг тогтоолгох сөрөг нэхэмжлэл тус тус гаргасан.


Арбитр: нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, дүрмийн холбогдох зохицуулалтыг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.



Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн тогтоол

Сөрөг нэхэмжлэлийн талаар шийдвэр гаргаагүй атлаа сөрөг нэхэмжлэл арбитрын бус маргаан гэж шийдвэрлэсэн нь тодорхой бус байна. Энэ шийдвэр нь Арбитрын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан 30 талуудын тэгш эрхийн зарчим зөрчиж байна. Арбитрын дүрмийн 3.3-д энэхүү дүрэм заагаагүй болон талуудын Спортын арбитрын бүрэлдэхүүн аль тохиромжтой, аль нэг талын эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр явуулна гэж заасантай нийцэхгүй гэж хүчингүй болгосон






Б.Нямжавын нэхэмжлэлтэй арбитрын маргаан


Нэхэмжлэлийн шаардлага: “Их хурд-9” наадмын морин уралдаан зохион байгуулах тухай комиссын азарганы уралдаанд хүрэн халзан азарга түрүүлсэнд тооцсон агуулгатай хэсгийг хүчингүй болгуулах тухай

Арбитр: Гуравдагч этгээд татах, мөн нотлох баримт гаргуулахаар шийдвэрлэсэн

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалда шатны шүүхийн тогтоолын үндэслэл

- Давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээнд нотлох баримт гаргуулахтай холбоотой асуудал хамаарахгүй гэж дүгнэж, гомдлыг хангаагүй






С.Батсайханы нэхэмжлэлтэй арбитрын маргаан

Нэхэмжлэлийн шаардлага: Цанын холбоо ТББ-ын ээлжит 8 дугаар их хурлаар Ерөнхийлөгчийн сонгууль хууль бус явагдсан болохыг тогтоолгох, сонгуулийг дахин явуулахын хариуцагчид даалгах

Арбитр: Хэргийн харьяалал тогтоож, Дээрх маргааныг спортын арбитрын маргаан гэж үзсэн.

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалда шатны шүүхийн тогтоолын үндэслэл

- Цанын холбоо ТББ-ын ээлжит 8 дугаар их хурлаар Ерөнхийлөгчийн сонгуулийн асуудлаар арбитрын хэлэлцээр хийх боломжгүй.
- Дүрмийн 26.4.4-д “Арбитрын хэлэлцээргүй ч арбитрт шууд хандах, нөгөө тал үүнийг эсэргүүцээгүй, хүлээн зөвшөөрсөн, хариу тайлбар гаргаж, мэтгэлцсэн нөхцөлд арбитрын хэлэлцээр хийсэнтэй адилтган үзэх” нөхцөл нь спортын арбитрын харьяаллын бус маргааныг өөрийн харьяалал хамааруулж дүгнэх үндэслэл болохгүй юм гэж 1 дэх заалтын хүчингүй болгосон.





МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



Анхаарал тавьсан та
бүхэнд баярлалаа

